



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Х.ГАНХУЯГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 35 06, Факс: (976-11) 31 13 81,
Цахим хуудас: www.mmhi.gov.mn

2024.01.16 № 01/111
танай 2023.12.08 -ны № 34 -Т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн асуулгын дагуу дараах хариуг үүгээр хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Дизель түлш болон Аи92 автобензинийн өнөөгийн нөөц, тасалдал үүссэн гол шалтгаан, нөхцөлийн талаар:

Монгол Улс 2021 онд нийт 1.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн, үүнээс 1.5 сая тонн шатахуун, 2022 онд нийт 1.9 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн, үүнээс 1.7 сая тонн шатахуун, 2023 онд нийт 2.4 сая тонн гаруй газрын тосны бүтээгдэхүүн, үүнээс 2.1 тус тус импортолсон.

Газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч улс болох ОХУ-ын Ангарскийн газрын тос боловсруулах үйлдвэр 2023 оны 8,9 дүгээр сард ээлжит урсгал засвар хийх болсон талаар 2023 оны 6 дугаар сард албан захидал ирсний дагуу газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран 7,8,9 дүгээр саруудад захиалах бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж, автобензин, дизель түлшний нөөц бүрдүүлэлтийг хангалттай хэмжээнд бүрдүүлсний үр дүнд 2023 оны 8-9 дүгээр саруудад манай улсын газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаагүй, нөөц бүрдүүлэлт хэвийн үргэлжилсэн. Үүнд:

- 7-р сард нийт 78 мян.тонн автобензин, 139.0 мян.тонн дизель түлш
- 8-р сард нийт 82.5 мян.тонн автобензин, 152.8 мян.тонн дизель түлш
- 9-р сард нийт 50.1 мян.тонн автобензин, 83.0 мян.тонн дизель түлш

Манай улсын импортлогч аж ахуйн нэгжүүд ОХУ-ын Роснефть компанитай байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу газрын тосны бүтээгдэхүүний худалдан авалтыг хэвийн үргэлжлүүлж байсан боловч ОХУ-ын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 1537 дугаар тогтоол гарч, түлш, шатахууны экспортыг түр хугацаанд хориглох болсны улмаас Монгол Улс руу ачигдах газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлт түр зогссон.

Энэ цаг үетэй давхцан ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга В.В.Володин 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс 25-ны өдрүүдэд манай улсад айлчлан төрийн дээд удирдлагуудтай уулзах үеэр дээр дурдсан түлш, шатахууны экспортыг хориглох тухай тогтоол Монгол Улсад хамаарахгүй болохыг мэдэгдсэн.

Улмаар 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн ОХУ-ын Засгийн газрын 1637 дугаар тогтоолоор манай улсад хамаарах экспортын хоригийн хэсгийг сулруулж, "Роснефть",

1508 06 0057

“НефтеХимСервис”, “Газпром” зэрэг ОХУ-ын томоохон нийлүүлэгчдийг хоригоос чөлөөлж, бусад жижиг трейдер компаниудыг хоригт хэвээр үлдээсэн.

Хориг эхэлсэн өдөр буюу 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд нийт 21 хоногийн хугацаанд Монгол Улсад автобензин, дизель түлшний нийлүүлэлт хийгдээгүй бөгөөд энэ үеийг өмнөх саруудад бүрдүүлсэн нөөцөөр зохицуулалт хийх арга хэмжээг авсан.

2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр ОХУ-ын Эрчим хүчний сайдын тушаалаар трейдер компаниудын хоригийг зөвхөн автобензин дээр чөлөөлсөн тухайгаа мэдэгдсэн бөгөөд өвлийн дизель түлш дээр трейдер компаниудын хориг хэвээр үргэлжилж байна.

Эдгээр нөхцөл байдлын улмаас 2023 оны сүүлийн саруудад газрын тосны бүтээгдэхүүний хангамж, зохицуулалтад тодорхой асуудлууд үүссэн боловч тус яамны зүгээс холбогдох байгууллагууд, импортлогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилласны дүнд нийлүүлэлтийг тогтворжуулж, хангамж, түгээлт хэвийн түвшинд шилжээд байна.

Хоёр. Нийлүүлэлтийн төлөв байдал, хүлээгдэх хоног хугацаа авах арга хэмжээний талаар:

ОХУ-ын дотоодын төмөр замын эргэлтээс шалтгаалан Ангарскийн үйлдвэрээс бусад үйлдвэрээс ачигдсан шатахуун манай улсад багадаа 21 хоногийн дараа ирдэг. Харин Ангарскийн үйлдвэрээс ачигдсан шатахуун 4-7 хоногт нийлүүлэгддэг тул 2023 оны 12 дугаар сард шатахуун хангамжийн тогтвортой бус байдлыг шийдвэрлэх чиглэлээр Ангарскийн үйлдвэрээс нийлүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан.

Мөн ОХУ-ын дотоодын төмөр замын ачаалалтай холбоотойгоор шатахуун ачсан вагонууд төмөр замын өртөөнүүд дээр саатаж байгаа асуудлыг шийдвэрлэх, вагонуудын ачилтын зөвшөөрлийг шуурхай олгох, манай улсын импортлогч аж ахуйн нэгжүүдийн сар тутмын захиалгыг бүрэн баталгаажуулах, баталгаажуулсан хэмжээгээр сар сард нь ачилтыг хийж байх чиглэлд тодорхой шийдвэрүүд гаргуулсан.

2023 оны 12 дугаар сард ОХУ-ын “Роснефть” компаниас 70,000 тонн, БНХАУ-аас 31,500 тонн дизель түлш, нийт 101,500 тонн дизель түлш, Аи-92 автобензинийн хувьд “Роснефть” компаниас 51,000 тонн, бусад үйлдвэрүүдээс зарим аж ахуйн нэгж 8000 тонн, нийт 59,000 тонн худалдан авахаар захиалга баталгаажуулсан.

Түүнчлэн шатахуун хангамжийн тогтвортой бус байдлыг ашиглан 2023 оны сүүлийн саруудад дизель түлшийг ихээр нөөцлөн зориудаар хиймэл хомстол үүсгэх, түлш нөөцлөн дамлан худалдаж, зах зээлийн бодит үнэ ханшийг шударга бусаар өсгөх зэрэг зүй бус асуудлууд цөөнгүй гарч байгааг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хяналт тавих, таслан зогсоох арга хэмжээ авч ажилласан.

Гурав. Дизель түлшний тасалдал үүссэнээр экспорт, импортод нөлөөлөх нөлөөлөл, улсын эдийн засагт үүсэж болзошгүй эрсдэлт нөхцөл байдлын талаар:

Хэдийгээр газрын тосны бүтээгдэхүүний гадаад эх үүсвэртэй холбоотойгоор нийлүүлэлтийн хэмжээ тодорхой хугацаанд буурсан ч 2023 онд газрын тосны

бүтээгдэхүүний импорт өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээр 500.0 гаруй мянган тонноор нэмэгдэж, 2.4 сая тоннд хүрсэн.

2022 онд 682 мян.тонн автобензин, 987.8 мян.тонн дизель түлш импортолж байсан бол 2023 онд 729 мянган тонн автобензин, 1.3 сая тонн дизель түлш тус тус импортолсон.

Дээрх тоо баримтаас харахад ОХУ-аас импортлох автобензин, дизель түлшний нийлүүлэлт хэвийн үргэлжилж байна.

Дөрөв. Улсын хэмжээнд өдөрт хэдэн тонн түлш зарцуулагдаж байгаа талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:

2023 оны байдлаар Аи-92 автобензинийн сарын дундаж хэрэглээ 58.0 мян.тонн байгаа бол дизель түлшний сарын дундаж хэрэглээ 105.0 мян.тонн байна. Үүнийг хоногийн хэрэглээнд шилжүүлэн тооцвол Аи-92 автобензин хоногт дунджаар 1900-2000 орчим тонн, дизель түлш 3500 тонн орчим байна.

Уул уурхайн салбарын дизель түлшний хэрэглээ нийт хэрэглээний 60 орчим хувийг эзэлж байгаа бол Аи-92 автобензинийн борлуулалтын ихэнх хувийг жижиглэнгээр суудлын тээврийн хэрэгсэлд түгээмэл хэрэглэж байна.

Тав. Өдөрт зарцуулагдах хэрэгцээг хэр хэмжээнд хангаж чадаж байгаа талаар:

Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн бүрдүүлэх компанийн нөөцийн төрөл, тоо хэмжээг жил бүр Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлуулдаг.

Үүний дагуу 2024 оны газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн төрөл, хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг Засгийн газрын 2023.10.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 385 дугаар тогтоолоор батлуулсан.

2024 онд нийт 53 ААН 146,500 тонн газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх бөгөөд үүнд:

- А-80 автобензин 2,300 тонн;
- Аи-92 автобензин 53,800 тонн;
- Дизель түлш 83,200 тонн;
- ТС-1 3,700 тоннд
- Шатдаг хий 3,500 тонн тус тус байна.

Зургаа. Дизель түлшний хомстолоос ангижрах ямар гарц гаргалгаа, ойрын болон хэтийн төлөв байдал, авах арга хэмжээний талаар:

Газрын тосны бүтээгдэхүүний импортын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд БНХАУ-ын “Петрочайна Интернэйшнл” компанитай зарим аж ахуйн нэгж бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулсан бөгөөд Гашуунсухайт болон Шивээхүрэн, Ханги зэрэг боомтуудаар газрын тосны бүтээгдэхүүн импортлох бэлтгэл ажил зохих түвшинд хангагдаж, улмаар БНХАУ-аас импортолж буй бүтээгдэхүүний хэмжээ 7 хувь болж нэмэгдсэн.

Цаашид энэ хэмжээг нэмэгдүүлэх чиглэл баримтлан ажиллаж байгаа бөгөөд БНХАУ-аас худалдан авах бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх, ачилт тээвэрлэлтийг зохицуулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Газрын тосны бүтээгдэхүүний экспортыг түр хориглох тухай ОХУ-ын Засгийн газрын 09 дүгээр сарын 22, 10 дугаар сарын 05-ны өдрийн тогтоолууд, ачилт, тээвэрлэлтийн үеийн хязгаарлалт, саатал, дотоодын төмөр замын ачаалал, зохицуулалт зэрэг шалтгаануудын улмаас ОХУ-аас Монгол Улсад нийлүүлэх шатахуун тэр дундаа Евро-5 шатахууны нийлүүлэлт багассан. Иймд К5 /Евро-5/ шатахууны нийлүүлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх асуудлыг ОХУ, БНХАУ-ын өндөр хэмжээний айлчлалын хүрээнд тухайлбал УИХ-ын дарга Г.Занданшатар, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар нарын айлчлалын хүрээнд хийсэн уулзалт, яриа хэлэлцээрийн саналд болон Монгол, ОХУ хоорондын Засгийн газрын комиссын 25 дугаар хуралдааны Протокол болон төлөвлөгөөнд тус тус тусгуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2023 оны 06 дугаар сард БНХАУ-д хийсэн албан айлчлалаар Хятадын газрын тосны CNPC, Senores компаниудтай хийсэн яриа, хэлцэл тохиролцсоны дагуу БНХАУ-аас газрын тосны бүтээгдэхүүний худалдааны үйл ажиллагаа эрчимжиж шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүд “Петрочайна интернэшнл” компаниас нийт 30.0 мянган тонн дизель түлш худалдан авах захиалга, гэрээ хэлэлцээ хийсэн.

Мөн Монгол Улсад нийлүүлэх шатахууны ачилт, төмөр замын эргэлт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг хурдасгах, цаашид шатахууны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад чиглэлээр ОХУ, БНХАУ-ын төрийн холбогдох байгууллагууд, Монгол Улсад суугаа элчин сайдын яамд, 2 улсын шатахуун экспортлогч аж ахуйн нэгжүүдтэй бүх түвшинд хамтран ажиллаж байна.


Өвөлжилт хүндрэлтэй байгаа цаг үеийн онцлог байдлыг харгалзан 21 аймаг, 330 сумын мэдээг тус яаман дээр нэгтгэж, шаардлагатай газруудад шатахуун, түлш шуурхай хүргэх ажлыг зохион байгуулсан.

Долоо. Түлш шатахууны тасалдлаас үүдэлтэй өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэд хэрхэн нөлөөлж байгаа нөлөөллийг судалсан эсэх, судалгааны талаар:

Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-д үүсээд буй нөхцөл байдал болон дээр дурдсан экспортын хоригтой холбоотой ОХУ-ын Засгийн газрын тогтоол, холбогдох бусад шалтгаанаас хамааралтайгаар автобензин, дизель түлшний нийлүүлэлтийн хэмжээ тодорхой хугацаанд буурсан боловч тасалдалгүй.

Түүнчлэн түлш, шатахууны жижиглэн борлуулалтын үнэ тогтвортой хэвээр байгаа бөгөөд дээр дурдсан нөхцөл байдалтай холбоотойгоор үнийн хувьд ямар нэгэн өөрчлөлт гараагүй тул өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсөх нөхцөл бүрдээгүй болно.

САЙД



Ж.ГАНБААТАР